



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Л.ЦЭДЭВСҮРЭН ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: <http://iaac.mn>

2022 04 27 № 05/5788
танай _____-ны № _____-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

Боловсрол, шинжлэх ухааны яамны Санхүүгийн хэлтсийн төрийн сангийн төлбөр тооцоо, төсвийн гүйцэтгэл хариуцсан мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Мөнхбатын Ууган-Эрдэнэ, Хөрөнгө оруулалтын хэлтсийн газар зүйн мэдээллийн системд суурилсан хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хөгжүүлэлт, зохицуулалт хариуцсан шинжээчээр томилогдохоор нэр дэвшсэн Төмөрбаатарын Амартүвшин нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3-т "Ерөнхий шалгалтыг төрийн жинхэнэ алба хаах хүсэлтэй, энэ хуулийн 22.1-д заасан шаардлагыг хангасан иргэнээс, тусгай шалгалт /тухайн албан тушаалын/-ыг мөн хуулийн 27.1.1, 27.1.2-т заасан төрийн албан хаагчаас болон мөн хуулийн 27.1.3-т заасан нөөцөд байгаа иргэдээс тус тус авна", мөн Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 14 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам"-ын 7 дугаар зүйлийн 7.2-т "Зөвлөл, Салбар зөвлөл нь сонгон шалгаруулалтын тайланг хянаж, шалгалтаар хамгийн өндөр оноо авсан иргэнийг албан тушаалын сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлнэ" гэж тус тус заажээ.

Нэр дэвшигч М.Ууган-Эрдэнэ нь дээрх албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад ороогүй байх тул дээрх тогтоолоор батлагдсан журамд нийцүүлэн Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн томилох эсэх асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР



Т.ЭНХБОЛД

142203009208